



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 04 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

Г Т

Өрхийн эрүүл мэндийн төвийн
дүрмийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэм”-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрмийг мөрдүүлж, мэргэжил арга зүйгээр тогтмол хангаж, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.
3. Тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Бодлого төлөвлөлтийн газар /Д.Төмөртогоо/, Эмнэлгийн тусlamжийн газар /Я.Буянжаргал/, Ерөнхий мэргэжлийн салбар зөвлөл /С.Сонин/ нарт даалгасугай.
4. Энэ тушаалыг 2017 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД

А.ЦОГЦЭЦЭГ





ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Өрхийн эрүүл мэндийн төв (цаашид "төв" гэх) нь хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусlamж, үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх чиг үүрэг бүхий, сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага мөн.

1.2 Төв нь үйл ажиллагаандaa Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, "Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа"-ны стандарт болон энэхүү дүрмийг мөрдлөг болгон ажиллана.

1.3 Төв нь нөхөрлөл эсхүл компани хэлбэрээр зохион байгуулагдсан хуулийн этгээд байна. Төвийг аймаг, нийслэлийн төв болон хүн ам төвлөрсөн суурин газарт байгуулна.

1.4 Төв нь улсын бүртгэлд бүртгүүлэн, холбогдох хууль, журмын дагуу эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд байна.

1.5 Төв нь оноосон нэртэй байх бөгөөд албан ёсоор баталгаажсан тамга тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

1.6 Өрхийн эрүүл мэндийн төвд ногдох иргэний доод хязгаар 8000-аас доошгүй байна.

1.7 Төвийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

1.8 Төвийг үүсгэн байгуулах, өөрчлөх, нэгтгэх, татан буулгахтай холбоотой харилцааг Нөхөрлөлийн тухай хууль, Компаний тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, эрхзүйн актаар зохицуулна.

1.9 Төв нь шударга өрсөлдөөний зарчмаар ажиллах ба улс төрийн аливаа үйл ажиллагаанаас ангид байна.

Хоёр. Төвийн бүтэц, зохион байгуулалт, удирдлага

2.1 Төв нь "Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа"-ны стандартад заасан бүтэцтэй байна.

2.2. Төв нь иргэдэд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусlamж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хүний нөөц, эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, эм, техник хэрэгсэл, зориулалтын эмнэлгийн байраар хангах асуудлыг аймаг, нийслэлийн Засаг дарга, Эрүүл мэндийн газар, Өрхийн эрүүл мэндийн төвийн байгуулсан гүйцэтгэлийн гэрээнд тусгаж, хэрэгжүүлнэ.

2.3. Төв нь нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан тохиолдолд доорх заалтыг мөрдөнө. Үүнд:

2.3.1. Төв нь нөхөрлөлийн аль ч хэлбэрээр зохион байгуулагдаж болох бөгөөд тухайн төвд ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтний 70-аас доoshгүй хувь нь нөхөрлөлийн гишүүнд хамрагдсан байна. Төвийн бусад ажилчид нөхөрлөлийн гишүүнд орохгүй.

2.3.2. Гишүүд нөхөрлөлд гишүүнээр элсэх, гишүүнээс татгалзах асуудлыг Нөхөрлөлийн тухай хуулиар зохицуулна.

2.3.3. Төвийн удирдлага нь нөхөрлөлийн бүх гишүүдийн хурал байна. Шийдвэрийг нөхөрлөлийн гишүүдийн олонхийн саналаар гаргаж, шийдвэртэй холбогдон үүсэх хариуцлагыг хамтран хүлээнэ.

2.3.4. Нөхөрлөлийн бүх гишүүдийн хурлаас тус төвийн даргыг томилж, чөлөөлнө.

2.4. Төв нь компани хэлбэрээр зохион байгуулагдсан тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөлтэй байх ба "Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай" хуулийн 15 дугаар зүйлд заасан заалтыг мөрдөж ажиллана.

2.5. Төвийн дарга нь өрхийн эмчийн мэргэжил эзэмшсэн, мэргэжлээрээ 3-аас доoshгүй жил ажилласан, мэргэжлийн болон удирдахуйн ур чадвартай, хамт олны дунд нэр хүндтэй, багаар ажиллах чадвартай хүн байна. Удирдахуйн ухаанаар суралцсан бол давуу тал болно.

2.6. Төвийн дарга нь ил тод, нээлттэй, шударга, хамт олныг манлайлах, багаар ажиллах байдлыг үйл ажиллагааны үндсэн зарчмаа болгож, төвийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

2.7. Төвийн дарга нь гэрээ, бусад эрх зүйн баримтыг баталгаажуулах, байгууллагын хэтийн болон тухайн жилийн төлөвлөгөө, хөрөнгийн зарцуулалтыг хамт олны хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллан хамт олон болон тухайн нутаг дэвсгэрийн хүн амыг мэдээллээр хангана.

2.8. Төвийн даргыг 4 жил тутамд шинэчлэн томилох ба үр дүнтэй ажиллаж байгаа тохиолдолд иргэд, хамт олны саналаар 1 удаа улируулан сонгож болно.

2.9. Төвийн даргыг бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө дараах үндэслэлээр чөлөөлнө. Үүнд:

2.9.1. эрүүл мэндийн болон бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан,

2.9.2. гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон,

2.9.3. өөр ажилд шилжих болсон,

2.9.4. тухайн төвтэй байгуулсан гүйцэтгэлийн гэрээнд тусгасан эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний үндсэн үзүүлэлт сүүлийн 2 жил дараалан аймаг, нийслэл, дүүргийн дунджаас, эмнэлгийн тусlamж үйлчилгээ доголдсон тохиолдолд,

2.9.5. манлайлан удирдан зохион байгуулах ур чадваргүй, багаар ажилладаггүй, ёс зүй, харилцаа хандлагын зөрчил гаргасан нь нотлогдсон, дотоодын хяналт хийж, түүний мөрөөр арга хэмжээ авахуулсан, хамт олноос чөлөөлж өгөх хүсэлт гаргасан.

2.10. Төвийн дарга нь эмч, ажиллагсадтай “Хөдөлмөрийн тухай” хуульд заасны дагуу хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллана.

2.11. Төвийн дотоод журмыг боловсруулан хамт олны хурлаар хэлэлцэн баталж, мөрдөж ажиллана.

2.12. Төв нь үзүүлж буй тусlamж, үйлчилгээний чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтэн, сувилагчийг жил бүр багц цагийн сургалтад хамруулсан байна.

2.13. Төвийг шинээр байгуулах, бүтэц зохион байгуулалтыг өөрчлөхөдаймаг дүүргийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын даргын саналыг үндэслэнэ.

Гурав: Төвийн санхүүжилт

3.1. Төвийн санхүүжилт нь улсын болон орон нутгийн төсөв, эрүүл мэндийн даатгалын санхүүжилт, нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн санхүүжилт, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

3.2. Төв нь үйлчлэх хүрээний иргэдийн тоог хагас бүтэн жил тутам гарган, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлэн санхүүжилтийн хэмжээг тогтоолгоно.

3.3 Төвийн санхүүжилтийг “Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай” хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалтад зааснаар олгоно.

3.5. Тухайн төвөөр үйлчлүүлсэн хөдөлгөөнт хүн ам, бүртгэлгүй иргэн, түр оршин суугаа иргэдэд үзүүлсэн тусlamж, үйлчилгээний гүйцэтгэлд үндэслэн, тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар бодож олгоно.

3.6. “Эрүүл мэндийн даатгалын тухай” хуулийн 9.1-д заасан тусlamж үйлчилгээг үзүүлсэн тохиолдолд эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтийг олгоно.

3.7. Төвийн байрны тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж болно.

3.8. Төв нь төсвийн гүйцэтгэлийн мэдээг нэг иргэнээр тооцсон зардлаар гарган сар бүр харьяа аймаг, дүүргийн Төрийн сангийн газар /хэлтэс/-т хүргүүлнэ.

3.9. Санхүүгийн тайланг “Нэгтгэсэн санхүүгийн тайлан ба хяналтад байгаа байгууллагын нягтлан бодох бүртгэл” стандартын дагуу гаргаж тайлангийн нэгтгэлд хамруулна.

Дөрөв. Төвийн үйл ажиллагаа

4.1. Төв нь өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт болон тусlamж, үйлчилгээний багцад заасан нийгмийн болон эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг иргэдэд чанар, хүртээмжтэй, чирэгдэлгүй үзүүлнэ.

4.2. Үйлчлүүлэгчдийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний хэрэгцээ, шаардлагыг зөв тодорхойлж, шаардлагатай лавлагаа, тусlamжийг хугацаа алдалгүй зохион байгуулан тусlamж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж ажиллана.

4.3. Түр оршин суугч болон бүртгэлгүй иргэдэд эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг үзүүлнэ.

4.4. Гамшиг, осол, нийтийг хамарсан халдварт өвчин, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал үүссэн үед харьяа байгууллагын шийдвэрийг мөрдөж, тусlamж үйлчилгээг шуурхай үзүүлнэ.

4.5. Хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандан судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох зэрэг нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг зохион байгуулан, үнэлж, үр дүнг тооцож ажиллана.

4.6. Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр ажиллаж байгаа олон нийтийн байгууллага, хөдөлгөөн, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллана.

4.7. Харьяалах шатны Засаг дарга, цагдаа, бүртгэлийн байгууллагын дэмжлэгийг авч, эрүүл мэндийн талаарх мэдээллээр ханган, хамтарч ажиллана.

Тав. Төвийн гэрээ

5.1. Төв нь аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газартай гүйцэтгэлийн гэрээг тухайн жилийн эхний 1 сард багтаан байгуулна.

5.2. Гэрээг аймаг, нийслэлийн засаг даргын захирамжаар батлагдсан 3 талын төлөөлөл оролцсон баг ил тод, шударга нээлттэй зарчмыг баримтлан тэгш эрхтэй оролцон, жил бүр харилцан дүгнэж, үр дүнг үйлчлэх хүрээний хүн амд танилцуулна.

5.3. Гэрээнд заасан үүргээ хангалтгүй биелүүлсэн, эсхүл дараалан 2 удаа “ажил сайжруулах шаардлагатай” үнэлгээтэй дүгнэгдсэн, эсхүл гэрээг тогтоосон хугацаанд байгуулаагүй тохиолдолд гэрээний дагуу хариуцлага тооцож, гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

5.4. Гэрээг цуцалсан тохиолдолд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Өрхийн эрүүл мэндийн төвийн багийг сонгон шалгаруулах журам”-ын дагуу дараагийн өрхийн эрүүл мэндийн төвийн багийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар шалгаруулна.

5.5. Багийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах хүртэлх хугацаанд эмнэлгийн тусlamж, үйлчилгээг тасралтгүй явуулах үүргийг өмнө нь гэрээ байгуулсан өрхийн эрүүл мэндийн төвийн баг гүйцэтгэнэ.

Зургаа . Төвийн үүрэг, эрх

6.1. Төв нь дараах үүргийг хүлээнэ:

6.1.1. Эрүүл мэндийн тухай хуульд заасан эрүүл мэндийн байгууллагын нийтлэг үүрэг хүлээх,

6.1.2. байгууллагын үндсэн зорилго, зорилт, чиг үүргийг тодорхойлон, үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр гарган баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах,

6.1.3. үйлчлүүлэгчийн эрхийг хүндэтгэх, өрхийн эмчээ сонгох, тусlamж, үйлчилгээ авах ээлтэй орчин бүрдүүлэх,

6.1.4. эрүүл мэндийн чанартай тусlamж, үйлчилгээг хүrtээмжтэй үзүүлж, эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтэд судалгаа дүгнэлт хийн, үr дүнг тооцож, зөвлөгөө өгөх цогц аргыг эзэмшин иргэдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд анхаарч ажиллах,

6.1.5. төвийн ажилтнууд нь эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдөж мэдлэг, ур чадвараа байнга дээшлүүлэх,

6.1.6. төв нь эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудын цалин, урамшууллыг гүйцэтгэлийн үнэлгээнд тулгуурлан, үнэн зөв, ил тод олгох,

6.1.7 эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас баталсан анхан шатны маягтыг хөтөлж, тайлан мэдээг хугацаанд нь гаргаж, хүргүүлэх,

6.1.8. өмч, хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хамгаалалт, зарцуулалтад хяналт тавих,

6.1.9. эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургах, тогтвортой суурьшилтай ажиллуулах боломж нөхцөлөөр хангах,

6.1.10. ажилтны нийгмийн асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлэх.

6.2. Төв нь дараах эрхийг эдэлнэ:

6.2.1. "Эрүүл мэндийн тухай" хуульд заасан эрүүл мэндийн байгууллагын нийтлэг эрхийг эдлэх,

6.2.2. нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусlamж, үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн шинэ санаа, санаачилга дэвшүүлэх, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх санал хүсэлт тавьж шийдвэрлүүлэх,

6.2.3. эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг зохион байгуулахад иргэн, гэр бүл, хамт олныг оролцуулах, аж ахуйн нэгж, байгууллагад эрүүл ахуй, халдварт хамгааллын хэвийн нөхцөлийг хангуулахад чиглэсэн заавар, зөвлөгөө өгөх, шаардлага тавих,

6.2.4. хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй асуудлыг орон нутгийн засаг захиргаанд тавьж, шийдвэрлүүлэх,

6.2.5. нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн шинэ санаа, санаачилга дэвшүүлэх, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх санал хүсэлтийг холбогдох байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх,

6.2.6. төвд хуваарилагдаж буй санхүүжилтийг хугацаанд нь авч, зориулалтын дагуу захиран зарцуулах,

6.2.7. төвийн үйл ажиллагаа, санхүүтэй холбоотой асуудлаар санал, хүсэлт гаргах, шийдвэрлүүлэх,

6.2.8. тухайн өрхийн эмчийг сонгон бүртгүүлсэн хүн амын тоо, тусlamж, үйлчилгээний чанар, хуртээмж, үр дүнгээс хамааруулан ажилтнуудын цалингийн хэмжээг тогтоох, нэмэгдэл олгох,

6.2.9. эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж авах,

6.2.10. Эрүүл мэндийн тухай хуульд заасан нийгмийн баталгааг эдэлж, нэмэгдэл хөлс, нөхөн төлбөр авах.

Долоо. Бусад

7.1. Төв нь төрийн болон орон нутгийн өмчийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу ашиглана.

7.2. Улс, орон нутгийн төсөв, төсөл, хандив, хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэгдсэн хөрөнгийг аймаг, нийслэлийн өмчийн харилцааны газарт бүртгүүлнэ. Өмчийн ашиглалт, хамгаалалтад орон нутгийн өмчийн харилцааны газар хяналт тавьж ажиллана.

7.3. Төвийн байрны их засварыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэнэ. Барилгын урсгал засварыг төв хариуцан тухай бүр хийж гүйцэтгэнэ.

7.4. Төв татан буугдсан тохиолдолд талуудын төлөөллийг оролцуулан төвийн хөрөнгийг шилжүүлэх үйл ажиллагааг аймаг, нийслэлийн өмчийн харилцааны газар хариуцан гүйцэтгэнэ.

7.5. Харьяалах нутаг дэвсгэрт тусlamж, үйлчилгээ үзүүлж буй төвийн болон шинээр төв байгуулах тохиолдолд хэрэгцээтэй байр, хөрөнгө, эмнэлгийн багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах болон санхүүжилтийн асуудлыг Аймаг, нийслэлийн засаг дарга хариуцан шийдвэрлэнэ.

---Оо---